



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Нямаагийн ЭНХБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-03-85, Факс: 26-29-92
E-mail: enkhbold@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.01.19 № ЧЦХ-03/579
танай _____-ны № _____-т


Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд бид "Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газраас ирүүлсэн дүгнэлтийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



 Н.ЭНХБОЛД
 Б.БАТ-ЭРДЭНЭ
 Б.ПҮРЭВДОРЖ
 Ц.СЭРГЭЛЭН
 Т.ТЭМҮҮЛЭН
 Б.ЭНХ-АМГАЛАН

000011



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Нямаагийн ЭНХБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-03-85, Факс: 26-29-92
E-mail: enkhbold@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.01.17 № УИХ-03/409
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**


Монгол Улсын үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасан бүрэн эрхийнхээ дагуу “Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулсныг хянан үзэж Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газраас ирүүлсэн дүгнэлтийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 01 дугаар
сарын 11-ны өдөр

Дугаар хэт/64

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.ЭНХБОЛД
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

“Х.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын санаачлан боловсруулсан Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоос санаачлан боловсруулсан Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Төсвийн тухай хуулийн 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” зарчмыг анхаарч, хуулийн төслийн тандан судалгаанд дурдагдсан 2018, 2019 онуудад үүссэн гаалийн татварын өр төлбөр болох 114,341,684.00 (нэг зуун арван дөрвөн сая гурван зуун дөчин нэгэн мянга зургаан зуун наян дөрвөн) төгрөгийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг танилцуулгад тусгах;

2. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн бүтэц, зүйл хоорондын уялдаа, бусад хууль тогтоомжтой уялдсан байдал, эх бичвэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлага зэргийг анхаарч боловсруулах.” гэжээ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР